

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр, Адагийн хайлуур жоншны далд уурхай ба баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ

3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 23–ны өдрийн 15:00 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 05 дугаар сарын 28 – ны өдрийн 09:00 цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр
Утас: 458401, Факс: 458380**